ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улсын филармонийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: САГ-2026/237/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг<br>Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: И.Эрдэнэцэцэг<br>Утас: Цахим хаяг: erdenetsetsege@audit.gov.mn<br>Аудитор: Т.Нямсүрэн<br>Утас: Цахим хаяг: nyamsurent@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Эс Жи Эм Ди-Аудит ХХК<br>Захирал: Д.Насанжаргал<br>Утас: 99996948 Цахим хаяг: nasaa@sgmd-audit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** .....3

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** .....5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....6

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....8

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....11

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....13

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** .....14

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....14

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....14

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....14

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....15

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....16

**4. АУДИТЫН ТАЙЛАН** .....19

4.1 Ерөнхий зүйл .....19

4.2 Материаллаг байдал .....19

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....19

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....19

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....22

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....23

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** .....24

5.1 Албан шаардлага .....24

5.2 Зөвлөмж .....25

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** .....27


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БНСУ | Бүгд Найрамдах Солонгос Улс |
| ДБЭТ | Дуурь Бүжгийн Эрдмийн Театр |
| МУБИС | Монгол Улсын Боловсролын Их Сургууль |
| НДШ | Нийгмийн Даатгалын Шимтгэл |
| СУИС | Соёл Урлагийн Их Сургууль |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/412
танай ___________-ны №___________-т

УЛСЫН ФИЛАРМОНИЙН
ЗАХИРАЛ С.БАТТУЛГА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын филармонийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан төлөвлөгөөт сонгодог болон үндэсний урлагийн нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх эерэг үр нөлөөг нэмэгдүүлэх, хөгжмийн урлагийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг улам бүр хөгжүүлэхийн тулд 80 удаагийн концертыг зохион байгуулж нийт 1600 гаруй иргэдэд толилуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүй нийлүүлсэн 703,842.3 мянган төгрөгийн үнэ бүхий төгөлдөр хуур хөгжим нь ажлын даалгаврын шалгуур хангахгүй байгаа тул үйл ажиллагаанд ашиглахгүй байна.

Байгууллагын дүрэмд захиалгат тоглолтын үнийн тарифаас хөнгөлөлттэй үнээр үйлчилгээ үзүүлэх асуудлыг зохицуулаагүй байхад зарим төрийн болон төрийн бус байгууллагуудад байгууллагын даргын тушаал шийдвэргүйгээр захиалгат тоглолтын үнэ тарифаас хөнгөлөлттэй үнээр үйлчилсэн байна.

**Бусад асуудал**

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

Z:\Yawsan_Bichig\2026\0225 SAG-92.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (1)** | **545,772,690.99** | **903,720,079.50** |
| **33** | **АВЛАГА** | **69,054,065.00** | **101,917,172.00** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 321,065.00 | 2,064,772.00 |
| 33101 | Цалингийн авлага | 320,865.00 | - |
| 33102 | НДШ-ийн авлага | 200.00 | - |
| 33103 | ХХОАТ-ын авлага | - | 2,064,772.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 68,733,000.00 | 41,005,400.00 |
| 33500 | Бусад авлага | - | 58,847,000.00 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | - | 47,812,000.00 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | - | 11,035,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **476,718,625.99** | **801,802,907.50** |
| **35100** | **Түүхий эд материал** | **231,441,805.00** | **636,522,520.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 231,441,805.00 | 636,522,520.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 105,319,900.00 | 121,690,000.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **139,956,920.99** | **43,590,387.50** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 654,600.00 | 126,000.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 117,923,058.49 | 36,085,780.00 |
| 35440 | Түлш шатах тослох материал | - | 1,540,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 21,379,262.50 | 5,838,607.50 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,048,524,525.20** | **3,586,826,045.88** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **3,048,524,525.20** | **3,586,826,045.88** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **2,958,854,061.36** | **3,492,610,304.46** |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 306,200,000.00 | 326,200,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (149,677,777.74) | (183,411,111.06) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 3,854,582,816.70 | 4,865,536,081.70 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (1,142,305,420.90) | (1,592,870,880.53) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 137,538,184.50 | 146,854,869.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (56,223,543.69) | (77,542,067.60) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 8,963,900.00 | 8,963,900.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (224,097.51) | (1,120,487.55) |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **89,670,463.84** | **94,215,741.42** |
| 39301 | Програм хангамж | 6,238,890.00 | 6,238,890.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,637,592.85) | (3,987,315.29) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 87,500,000.00 | 99,700,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (1,430,833.31) | (7,735,833.29) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,594,297,216.19** | **4,490,546,125.38** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **78,868.47** | **55,869,476.92** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **76,868.47** | **55,869,476.92** |
| 413 | Өглөг | 76,868.47 | 43,633,028.92 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 76,868.47 | 536,464.92 |
| 41312 | НДШ-ийн өглөг | - | 536,464.92 |
| 41314 | ҮЭ-ийн өглөг | 76,868.47 | - |
| 41360 | Бусад өглөг | - | 55,333,012.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 55,333,012.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)** | **3,594,220,347.72** | **4,434,676,648.46** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **3,594,220,347.72** | **4,434,676,648.46** |

| | | | |
|---|---|---|---|
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 390,738,376.57 | 390,738,376.57 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **3,203,481,971.15** | **4,043,938,271.89** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,102,100,797.96 | **3,203,481,971.15** |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 1,101,381,173.19 | 840,456,300.74 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,594,297,216.19** | **4,490,546,125.38** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *(/төгрөгөөр/)*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **6,947,723,322.41** | **8,042,549,669.39** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,310,466,969.49** | **8,042,549,669.39** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **1,310,466,969.49** | **1,551,847,168.00** |
| 120009 | Бусад орлого | - | 344,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 1,184,214,250.00 | 1,120,814,600.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 126,252,719.49 | 430,688,568.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | **-** | **6,490,702,501.39** |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | - | 6,490,702,501.39 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | - | 5,860,561,800.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | - | 5,860,561,800.00 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 630,140,701.39 |
| 122134 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 75,000,000.00 |
| 122135 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 555,140,701.39 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **5,637,256,352.92** | **-** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 4,847,290,600.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 4,847,290,600.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **789,965,752.92** | **-** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 201,200,752.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 588,765,000.92 | - |
| **12** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО** | **1,310,466,969.49** | **1,551,503,168.00** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,310,466,969.49 | 1,551,503,168.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 1,184,214,250.00 | 1,120,814,600.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 126,252,719.49 | 430,688,568.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **5,846,342,149.22** | **7,202,093,368.65** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,846,342,149.22** | **7,202,093,368.65** |
| **210** | **БАРАА,ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **5,686,708,264.44** | **6,961,286,242.57** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **3,836,937,828.35** | **4,885,607,879.88** |
| 210101 | Үндсэн цалин | 2,360,485,711.49 | 2,964,549,447.32 |
| 210102 | Нэмэгдэл | 766,253,161.05 | 899,183,666.74 |

| | | | |
|---|---|---|---|
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 415,456,649.26 | 766,014,578.93 |
| 210104 | Урамшуулал | 242,123,259.43 | 255,860,186.98 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 52,619,047.12 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **483,434,255.14** | **611,822,209.63** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 330,622,725.81 | 418,298,815.32 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 39,072,629.04 | 49,809,767.28 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 20,523,197.78 | 26,847,016.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 18,710,446.64 | 23,610,234.03 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 74,505,225.87 | 93,256,377.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **48,491,000.00** | **86,400,000.00** |
| 210304 | Байрны түрээс | 48,491,000.00 | 86,400,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **33,899,383.80** | **32,310,789.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 8,259,360.00 | 9,070,034.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,957,400.00 | 17,073,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,076,563.80 | 5,707,755.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 606,060.00 | 460,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **71,607,789.00** | **44,680,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 150,000.00 | 5,080,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 71,457,789.00 | 39,600,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **26,140,300.00** | **-** |
| 210701 | Гадаад албан томилолт | 76,200,752.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | - | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **459,471,465.32** | **356,288,350.25** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 454,299,465.32 | 351,288,350.25 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 172,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **676,665,820.83** | **944,177,013.81** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 235,001,286.50 | 314,874,994.49 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 441,664,534.33 | 629,302,019.32 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **159,633,884.78** | **240,807,126,08** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **159,241,770.56** | **209,370,977.98** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 49,660,000.00 | 38,300,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 80,881,770.56 | 155,270,977.98 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 28,700,000.00 | 15,800,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **392,114.22** | **31,436,148.10** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 363,175.62 | 28,112,461.96 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 28,938.60 | 3,323,686.14 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **1,101,381,173.19** | **840,112,300.74** |
| **14** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО** | **-** | **344,000.00** |
| 140 | Төсөвт байгууллагын орлого | - | 344,000.00 |
| 140020 | Дансны орлого | - | 344,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН ()** | **-** | **344,000.00** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **1,101,381,173.19** | **840,456,300.74** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **5,556,706,602.92** | **6,465,688,701.39** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **6,465,688,701.39** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **-** | **344,000.00** |
| 120009 | Бусад орлого | - | 344,000.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | **-** | **6,465,344,701.39** |
| **1221** | **Хандив тусламж /дотоод/** | **-** | **6,465,344,701.39** |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | - | 5,860,561,800.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | - | 5,860,561,800.00 |
| **12213** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **-** | **604,782,901.39** |
| 122134 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 75,000,000.00 |
| 122135 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 529,782,901.39 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **5,556,706,602.92** | **-** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **4,847,290,600.00** | **-** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 4,847,290,600.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **709,416,002.92** | **-** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 201,200,752.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 508,215,250.92 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)** | **5,394,946,902.92** | **6,465,688,701.39** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,394,946,902.92** | **6,465,688,701.39** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **5,235,313,018.14** | **6,224,881,575.31** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **3,837,231,151.05** | **4,892,290,235.55** |
| 210101 | Үндсэн цалин | 2,363,128,230.24 | 2,885,731,684.28 |
| 210102 | Нэмэгдэл | 762,206,419.91 | 891,591,686.03 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 370,662,746.56 | 793,885,300.00 |
| 210104 | Урамшуулал | 288,614,707.22 | 319,658,565.24 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 52,614,047.12 | 1,423,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **483,306,972.60** | **638,206,225.26** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 329,678,872.60 | 448,783,975.26 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 38,407,000.00 | 47,739,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 19,203,500.00 | 23,889,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 19,203,500.00 | 23,817,150.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 76,814,100.00 | 93,976,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **48,491,000.00** | **84,805,400.00** |
| 210304 | Байрны түрээс | 48,491,000.00 | 84,805,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **55,279,921.80** | **63,413,297.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 5,914,280.00 | 8,681,254.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,502,000.00 | 18,613,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,076,563.80 | 5,790,255.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 24,787,078.00 | 30,328,788.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **-** | **-** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **147,227,689.00** | **122,716,492.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 12,230,400.00 | 51,263,640.00 |
| 210602 | Тавилга | 363,500.00 | 15,999,300.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгаалал хэрэгсэл | 63,000,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 71,633,789.00 | 55,453,552.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **76,200,752.00** | - |
| 210701 | Гадаад албан томилолт | 76,200,752.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **587,575,431.69** | **367,002,009.50** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 582,309,195.32 | 367,002,009.50 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 5,000,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 94,236.37 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 172,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **100.00** | **56,447,916.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 100.00 | 56,447,916.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **159,633,884.78** | **240,807,126.08** |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | - | 31,436,148.10 |
| 21311 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | 31,436,148.10 |
| 213112 | Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 31,436,148.10 |
| 2131121 | Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 28,112,461.96 |
| 2131123 | Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал | - | 3,323,686.14 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **159,241,770.56** | **209,370,977.98** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 49,660,000.00 | 38,300,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 80,881,770.56 | 155,270,977.98 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 28,700,000.00 | 15,800,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **392,114.22** | **-** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 363,175.62 | - |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 28,938.60 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **161,759,700.00** | **-** |
| **14** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО** | **-** | **-** |
| 140 | Төсөвт байгууллагын орлого | - | - |
| 140020 | Дансны орлого | - | - |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (V)** | **-** | **-** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **161,759,700.00** | **-** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 161,759,700.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 161,759,700.00 | - |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **161,759,700.00** | **-** |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(161,759,700.00)** | **-** |

| | | | |
|---|---|---|---|
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **(100.00)** | **-** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 100.00 | - |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **390,738,376.57** | **-** | **2,102,100,797.96** | **2,492,839,174.53** |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 390,738,376.57 | - | 2,102,100,797.96 | 2,492,839,174.53 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 1,101,381,173.19 | 1,101,381,173.19 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **390,738,376.57** | **-** | **3,203,481,971.15** | **3,594,220,347.72** |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 390,738,376.57 | - | 3,203,481,971.15 | 3,594,220,347.72 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 840,456,300.74 | 840,456,300.74 |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **390,738,376.57** | **-** | **4,043,938,271.89** | **4,434,676,648.46** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **5,987,951,800.00** | **5,832,449,338.04** | **155,502,461.96** | **97.40** |
| 12 | Татварын бус орлого | 5,987,951,800.00 | 5,832,449,338.04 | 155,502,461.96 | 97.40 |
| 122 | Тусламжийн орлого | 5,987,951,800.00 | 5,832,449,338.04 | 155,502,461.96 | 97.40 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 5,987,951,800.00 | 5,832,449,338.04 | 155,502,461.96 | 97.40 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,987,951,800.00** | **5,832,449,338.04** | **155,502,461.96** | **97.40** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,987,951,800.00** | **5,832,449,338.04** | **155,502,461.96** | **97.40** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **5,772,490,900.00** | **5,628,878,360.06** | **143,612,539.94** | **97.51** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **4,823,214,400.00** | **4,815,363,234.80** | **7,851,165.20** | **99.84** |
| 210101 | Үндсэн цалин | 2,924,502,400.00 | 2,816,527,683.53 | 107,974,716.47 | 96.31 |
| 210102 | Нэмэгдэл | 783,616,900.00 | 891,591,686.03 | 107,974,786.03 | 113.78 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 793,885,300.00 | 793,885,300.00 | 0.00 | 100.00 |
| 210104 | Урамшуулал | 321,209,800.00 | 313,358,565.24 | 7,851,234.76 | 97.56 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **640,492,500.00** | **630,101,725.26** | **10,390,774.74** | **98.38** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 452,591,500.00 | 442,200,725.26 | 10,390,774.74 | 97.70 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 47,012,800.00 | 47,012,800.00 | 0.00 | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 23,577,200.00 | 23,577,200.00 | 0.00 | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 23,460,900.00 | 23,460,900.00 | 0.00 | 100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 93,850,100.00 | 93,850,100.00 | 0.00 | 100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **84,805,400.00** | **84,805,400.00** | **0.00** | **100.00** |
| 210304 | Байрны түрээс | 84,805,400.00 | 84,805,400.00 | 0.00 | 100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **3,161,800.00** | **1,960,244.00** | **1,201,556.00** | **62.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 498,100.00 | 200,170.00 | 297,930.00 | 40.19 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,316,800.00 | 791,212.00 | 525,588.00 | 60.09 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,346,900.00 | 968,862.00 | 378,038.00 | 71.93 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **107,519,800.00** | **12,519,840.00** | **94,999,960.00** | **11.64** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 107,519,800.00 | 12,519,840.00 | 94,999,960.00 | 11.64 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **32,657,100.00** | **27,680,000.00** | **4,977,100.00** | **84.76** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 27,680,000.00 | 27,680,000.00 | 0.00 | 100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 4,977,100.00 | 0.00 | 4,977,100.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **80,639,900.00** | **56,447,916.00** | **24,191,984.00** | **70.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 80,639,900.00 | 56,447,916.00 | 24,191,984.00 | 70.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 215,460,900.00 | 203,570,977.98 | 11,889,922.02 | 94.48 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 215,460,900.00 | 203,570,977.98 | 11,889,922.02 | 94.48 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 40,319,900.00 | 38,300,000.00 | 2,019,900.00 | 94.99 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 165,141,000.00 | 155,270,977.98 | 9,870,022.02 | 94.02 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,000,000.00 | 10,000,000.00 | 0.00 | 100.00 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | 0 | 100.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | 0 | 100.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 162 | 162 | 0 | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 0 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 153 | 155 | -2 | 101.31 |
| 620003 | Бичиг хэрэг | 8 | 6 | 2 | 75.00 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **604,782,901.39** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **604,782,901.39** |
| **12213** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **604,782,901.39** |
| 350014 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 75,000,000.00 |
| 350015 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 529,782,901.39 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **601,803,215.25** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **601,803,215.25** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **596,003,215.25** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **76,927,000.75** |
| 210101 | Үндсэн цалин | 69,204,000.75 |
| 210104 | Урамшуулал | 6,300,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 1,423,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **8,104,500.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,583,250.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 726,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 312,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 356,250.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 126,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **61,453,053.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 8,481,084.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,613,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,999,043.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 29,359,926.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **110,196,652.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 38,743,800.00 |
| 210602 | Тавилга | 15,999,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 55,453,552.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **339,322,009.50** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 339,322,009.50 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **5,800,000.00** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 5,800,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,800,000.00 |
| **4** | **ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ** | **2,979,686.14** |
| 5 | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,979,686.14 |
| 6 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 2,979,686.14 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улсын филармони нь эрхэм зорилгоо "Монгол төрийн соёлын бодлогыг хэрэгжүүлж, бүх нийтэд хөгжмийн урлагийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх" гэж тодорхойлсон байна.

Улсын филармони нь Монгол төрийн соёлын бодлогыг хэрэгжүүлж, бүх нийтэд хөгжмийн урлагийн үйлчилгээг үзүүлэх чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Улсын филармони нь Соёлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль болон Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 2024 оны 6 дугаар сард 6 дугаар зүйлийн 6.2.7-д “төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөрийн үр дүн болон гарцыг шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлж баталж, хэрэгжүүлэх”;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Сангийн сайдын 2025 оны А/112 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, тайлбар, зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”;
- Сангийн сайдын 2025 оны 240 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”.

Улсын Филармонийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тус байгууллагын 2025 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах  шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улсын филармонийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улсын филармонийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 884,042.5 мянган төгрөгөөр буюу 24.6 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 69,054.1 | 54,105.2 | (14,948.9) |
| Урьдчилж төлсөн тооцоо | 0.00 | 47,812.0 | 47,812.0 |
| Бараа материал | 476,718.6 | 801,802.9 | 325,084.3 |
| Үндсэн хөрөнгө | 3,048,524.5 | 3,586,826.0 | 538,301.5 |
| **Нийт хөрөнгө** | **3,594,297.2** | **4,490,546.1** | **896,248.9** |
| Өглөг | 76.9 | 55,869.5 | 55,792.6 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 3,594,220.3 | 4,434,676.6 | 840,456.3 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **3,594,297.2** | **4,490,546.1** | **896,248.9** |

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, урьдчилж төлсөн тооцоо, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данснууд байна.

Үүнд:

Авлага дансны үлдэгдэл 54,105.2 мянган төгрөг болсон нь тайлант оны эцсээр тоглосон тоглолтын тасалбар борлуулсан зуучлагчаас авах авлага 41,005.4 мянган төгрөг, ажилчдаас авах тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан 13,099.8 мянган төгрөгийн авлагыг тус тус бүртгэсэнтэй холбоотой;

Урьдчилж төлсөн тооцоо дансны үлдэгдэл 47,812.0 мянган төгрөг болсон нь тайлант онд харилцагчид гэрээт ажлын төлбөр болон бараа материалын үнийг урьдчилан шилжүүлсэнтэй холбоотой;

Бараа материал дансны үлдэгдэл 801,802.9 мянган төгрөг болж 325,084.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас үнэ төлбөргүй өгсөн 430,688.6 мянган төгрөгийн бараа материал болон 168,508.3 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч данс бүртгэлд тусган, 274,112.6 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсантай холбоотой байна;

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,586,826.0 мянган төгрөг болж, 538,301.5 мянган төгрөгөөр өссөн нь Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас үнэ төлбөргүй өгсөн 1,069,151.6 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч, эрх бүхий байгууллагын шийдвэрээр 20,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийн балансаас балансад шилжүүлэн авч, ТӨБЗГ-ын 2025 оны 601 дүгээр тогтоолоор 74,956.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан болон тайлант онд 629,302.0 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тооцсоноос шалтгаалсан;

Өглөг дансны үлдэгдэл 55,869.5 мянган төгрөг болж өссөн нь харилцагч байгууллагуудад төлөх 43,126.5 мянган төгрөгийн, НДШ-ийн өглөг 536.5 мянган төгрөгийн шимтгэлийг тус тус төлөөгүйтэй холбоотой.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ дансны үлдэгдэл 4,434,676.6 мянган төгрөг болж 840,456.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан.

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа санхүүгийн, няравын, нотны болон дуу бичлэгийн зэрэг нийт 6,238.9 мянган төгрөгийн өртөгтэй 4 программуудыг ашиглаж байгаа бөгөөд 3,987.3 мянган төгрөгийн хорогдуулга байгуулан санхүүгийн тайланд тусгасан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Улсын филармони нь 2025 оны төсвийн төсөлд улсын төсвийн  санхүүжилтээр 6,173,118.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, нийт зарлагыг санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт зардлыг 185,166.3  мянган төгрөгөөр бууруулж, 5,987,951.8 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2025 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулсан боловч дээд шатны байгууллагаас төсвийг шаардлагатай хэмжээнд баталж өгөөгүйгээс шалтгаалсан байна. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын дүн, нэр төрөл, мөн  зарлагын дүн, нэр төрлөөр төсвийн төслийн боловсруулаагүй байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Соёл урлаг хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардал, гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээний төлбөр, уран бүтээл хийлгэх зардал, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,987,951.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,860,561.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, нэмэлт санхүүжилтийн дансанд үйл ажиллагааны орлого 605,126.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,832,449.3 мянган төгрөг буюу 97.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 24,387.7 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 9,870.0 мянган төгрөг, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтыг 121,244.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна. Санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл болох 28,112.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2.  Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| | Соёл урлаг | 5,987,951.8 | 5,832,449.3 | 155,502.5 | 97.40 |
| 80101 | Үндсэн үйл ажиллагаа | 5,516,331.2 | 5,491,943.5 | 24,387.7 | 99.56 |
| 80103 | Гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээ | 17,680.0 | 17,680.0 | - | 100.0 |
| 80214 | Уран бүтээл хийлгэх | 10,000.0 | 10,000.0 | - | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэг | 175,141.0 | 165,271.0 | 9,870.0 | 94.37 |
| 81855 | Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт | 268,799.6 | 147,554.9 | 121,244.7 | 54.89 |

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

**Байгууллагуудын орон тооны цомхотголын талаар:** Эрх бүхий дээд байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу тухайн байгууллагын ажлын байрны чиг үүргийн шинжилгээ хийж, бүтцийг шинэчлэн зохион байгуулан, үзвэр үйлчилгээний албыг татан буулган, нэгтгэж, албаны даргыг ажлаас чөлөөлж, Морин хуурын найрал хөгжмөөс 15 хөгжимчин цомхтголд хамруулж нийт 16 ажлын байрыг царцаасан байна.

**Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын судалгааны талаар:** Тайлант онд бүтэц орон тоог 178 хүнээр төлөвлөн хоол, унааны хөнгөлөлтөнд 793,885.3 мянган төгрөгийг баталсан, гүйцэтгэлээр дунджаар 160 бүтэц орон тоонд 766,393.0 мянган төгрөгийг зарцуулсан. Улсын Филармонийн захирлын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/02 тоот тушаалаар хоолны мөнгийг 1 өдрийн 18.5 мянган төгрөгөөр тогтоон, 2025 оны 1 дүгээр сараас 11 дүгээр сарын цалингуудад тооцож олгосон байна. Мөн Улсын Филармонийн захирлын 2025 оны 12-р сарын 21-ны өдрийн А/35 тоот тушаалаар хоолны мөнгийг 1 өдрийн 35.5 мянган төгрөгөөр тогтоон, тайлант оны 12 дугаар сарын цалинд тооцон олгосон байна. Тайлант жилийн хугацаанд унааны хөнгөлөлтөнд 1 өдрийн 1.5 мянган төгрөгөөр тогтоон нөхөх төлбөрийг олгосон, үүнийг захирлын тушаалаар баталгаажуулаагүй байна.

**Гадаад томилолт, арга хэмжээний судалгааны талаар:** Тайлант онд гадаад албан томилолт, арга хэмжээнд зардал гаргаагүй байна.

**Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны талаар:** Тайлант онд сургалт, семинар, хурал зөвлөгөөнд зориулж зардал гаргаагүй байна.

**Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн судалгааны талаар:** Тайлант онд ТВ-24 телевизтэй хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан ажилласан, ажил, үйлчилгээ болон гэрээний төлбөр төлөөгүй байна.

**Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардлын судалгааны талаар:** Тайлант онд Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн дагуу төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 530,126.9 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 75,000.0 мянган төгрөг нийт 605,126.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 85,031.5 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 61,453.1 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 110,196.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 339,322.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж 3,323.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

***3.5.3.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн***

Тайлант онд Соёлын салбарт хэрэгжиж байгаа 2 төсөл хөтөлбөрт оролцон, 2 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | “Бүх нийтийн соёлын боловсрол-II” хөтөлбөр | 2025-2028 | “Бүх нийтийн соёлын боловсрол-II” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдаж буй арга хэмжээнд оролцох, сурталчлах түгээх | БНСУ-ын Ж-Арт хамтлагтай хамтрсан тусгай хэрэгцээт уран бүтээлч хүүхдүүдийг дэмжих “Ирээдүй – Бидний – Оролцоо” тоглолтын ДБЭТ-тай хамтран зохион байгуулж, Баянмонгол бигбэнд хамтлаг оролцсон. | 20,000.0 | 18,560.0 |
| 2 | “Хөгжмийг хүн бүрд 2025-2028” хөтөлбөр | 2025-2028 | Хөгжмийн урлагаар дамжуулан урлагын боловсрол олгох, хөгжмийн урлагыг олон нийтэд сурталчлах, ирээдүйн сонгогчдыг бэлтгэх | “Хөгжмийг хүн бүрд 2025-2028” төслийн хүрээнд МУБИС, СУИС, ШИХИХУТАГ их сургууль болон Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчид, Мэргэжил дээшлүүлэх институтын сургалтаар ирсэн хөдөө, орон нутгийн соёл урлагийн байгууллагуудын ажилтан, Улсын Хоёрдугаар эмнэлэг зэрэгт 5 удаагийн бүрэн хэмжээний тоглолт толилуулж нийт 900 хүнд хөгжмийн урлагаар үнэ төлбөргүй үйлчилсэн. | 50,000.0 | 50,000.0 |
| 3 | Дүн | | | | 70,000.0 | 68,560.0 |

**3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант онд 216,000.0 мянган төгрөгийн 10 бараа, ажил худалдан авахаар төлөвлөгөөг баталж, гүйцэтгэлээр 98,000.0 мянган төгрөгийн бараа болон засварын ажлыг шууд худалдан авч, 34,000.0 мянган төгрөгийн урсгал засварын ажлыг сонгон шалгаруулалтаар зохион байгуулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улсын филармонийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Улсын филармони, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, бараа материалын анхан шатны баримтын бүрлийг хангах, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн заалтын дагуу иж бүрэн гаргахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Эс Жи Эм Ди Аудит ХХК-ийн ахлах аудитор О.Алтанцэцэг, аудитын шинжээч Ч.Ням-Очир нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Б.Оюунцэцэг, захирал Д.Насанжаргал нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүү, нийцлийн аудитын газрын аудитор Т.Нямсүрэн, аудитын менежер И.Эрдэнэцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Улсын филармонийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 01/19 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 5,846,342.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 58,463.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь тэтгэвэрт гарсан ажилчдад олгосон нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг бусад тэтгэмжтэй давхардуулан олгоогүй, байгууллагын хөрөнгөөр гар утасны төлбөр төлөөгүй, хэвлэл захиалаагүй байгаа хэдий ч үйл ажиллагаанд ашиглагдах комьпютерийг цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 35,925.8 мянган төгрөгийн 9 зөрчлөөс 29,985.0 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 5,940.0 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өглөө.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

<u>*Илрүүлэлт* 1:</u> Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 5,940.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна", 3.1.1-т "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд", 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалттай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансанд мэдээлэх мэдээлэлийг бүрэн мэдээлж байх, зөвлөмж өгсөн.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Соёл, Спорт, Аялал Жуулчлал, Залуучуудын сайдын 2024 оны А/173 тоот тушаалаар баталсан байгууллагын дүрмийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ. Үүнд:

<u>*Илрүүлэлт* 1:</u> Үндсэн үйл ажиллагааны нэмэлт эх үүсвэрээс худалдан авсан 18,325.0 мянган төгрөгийн үнэ бүхий 5 ширхэг компьютерыг цахим дэлгүүрээс худалдан аваагүй. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцээгүй.

<u>*Шийдвэрлэсэн нь:*</u> Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т заасныг мөрдөж ажиллаагүй, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

<u>*Илрүүлэлт* 2:</u> Тайлант онд үндсэн үйл ажиллагааны нэмэлт эх үүсвэрээр стикер, карт болон паспортны гэр, тэмдэглэлийн дэвтрийн хавтас зэрэг 900 ширхэг 6,900.0 мянган төгрөгийн бараа материал бэлтгэхээр гэрээ байгуулан төлбөрийг шилжүүлсэн. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай нийцээгүй.

<u>*Шийдвэрлэсэн нь:*</u> Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах, хэрэгцээ шаардлагагүй хөрөнгө бэлтгэж нөөцөлдөг , зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

<u>*Илрүүлэлт* 3:</u> Байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2,955.6 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй 2 тээврийн хэрэгсэл эвдэрсэн, үйл ажиллагаандаа ашигладдаггүй, эвдрэл гэмтлийг тогтоосон дүгнэлт гаргаагүй, техник ашиглалтын дэвтэр хөтлөөгүй, стандарт шаардлага хангасан агуулах байхгүйгээс 1 ширхэг 6,600.0 мянган төгрөгийн их хуур хөгжим эвдэрсэн, мөн бэлтгэл сургуулилт хийхээр гэрээр авч явсан хөгжмийн ашиглалтанд хяналтыг

хэрэгжүүлээгүй. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1-т "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэж заасантай нийцээгүй.

*Өгсөн зөвлөмж:* Эвдэрч хэмхэрсэн, ашиглагдахгүй байгаа хөрөнгийг шийдвэр гарах эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгсөн.

*Илрүүлэлт 4*: Гэр медиа ХХК-тай байгуулсан "тасалбар худалдаалах зуучлалын гэрээ"-ний дагуу зуучлалын шимтгэлийг 2025 онд 3 хувь гэж гэрээнд заасан боловч гэрээнд өөрчлөлт оруулалгүй тайланд онд тасалбар худалдаалсан шимтгэлд 4 хувиар тооцож 1,805.2 мянган төгрөгийн шимтгэл олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах ", Тасалбар худалдаалах зуучлалын гэрээний 4.1-т “ Гэрээний ажлын хөлс буюу зуучлалын шимтгэлийг www. TICKET.mn цахим систем, түүний борлуулалтын сувгуудаар худалдаалагдсан тасалбар тус бүрийн үнээс дараахь хувиар тооцно” гэж заасантай тус тус нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.
*Өгсөн зөвлөмж:* Дотоод хяналтыг сайжруулаагүй, харилцагч байгууллагатай байгуулсан гэрээний заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж өгсөн.

*Илрүүлэлт 5*: Тайлант онд төвлөрүүлж, зарцуулсан үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого болох 526,459.2 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөө байхгүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д "төсвийн орлого" гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг", 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалын 5 дугаар зүйлийн 5.7-д "Орлогыг төлөвлөгөөгүй төсөвт байгууллагад үндсэн үйл ажиллагааны нэмэлт төсвийг зарцуулах эрх олгохгүй" гэсэн заасантай тус тус нийцээгүй.

*Өгсөн зөвлөмж*: Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогын төлөвлөгөө баталж, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2022 оны А/282 тушаалыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгсөн.

*Илрүүлэлт 6*: Тайлант онд дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүй нийлүүлсэн 703,842.3 мянган төгрөгийн үнэ бүхий төгөлдөр хуур хөгжим нь ажлын даалгаврын шалгуур хангахгүй байгаа тул үйл ажиллагаанд ашиглагдахгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1-т "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах;" гэж заасантай нийцээгүй.

*Өгсөн зөвлөмж*: Өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах зөвлөмж өгсөн.

*Илрүүлэлт 7*: Үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах дүрэм, журмыг боловсруулан баталж мөрдөж ажиллаагүйгээс тайлант онд зохион байгуулсан 29 тоглолтын 611 ширхэг урилгыг бусдад харилцан адилгүй тоогоор олгосон. Энэ нь Соёл, Спорт, Залуучуудын сайдын 2024 оны А/173 дугаар тушаалын 5 дугаар зүйлийн 5.2.5-д "Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам, заавар,аргачлал, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэх" гэж заасантай нийцээгүй.

*Өгсөн зөвлөмж*: Байгууллагын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах дотоод журмыг боловсруулан баталж, мөрдөн ажиллах зөвлөмж өгсөн.

*<u>Илрүүлэлт 8</u>*. Байгууллагын дүрэмд захиалгат тоглолтын үнийн тарифаас хөнгөлөлттэй үнээр үйлчилгээ үзүүлэх асуудлыг зохицуулаагүй байхад зарим төрийн байгууллага болон төрийн бус байгууллагуудад байгууллагын даргын тушаал шийдвэргүйгээр захиалгат тоглолтын үнийн тарифаас хөнгөлөлттэй үнээр үйлчилсэн байна. Энэ нь Соёл, Спорт, Аялал Жуулчлал, Залуучуудын сайдын 2024 оны А/173 тоот тушаалаар баталсан дүрмийн 7.1-т "Дүрэмд Соёлын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт өөрчлөлтийг тухай бүр улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ" гэж заасантай нийцээгүй.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*: Байгууллагын дүрэмд захиалгат тоглолтын үнийн тарифаас хөнгөлөлттэй үнээр үйлчилгээ үзүүлэх асуудлыг зохицуулаагүй байхад зарим төрийн байгууллага болон төрийн бус байгууллагуудад байгууллагын даргын тушаал шийдвэргүйгээр захиалгат тоглолтын үнийн тарифаас хөнгөлөлттэй үнээр үйлчлэхгүй байх, дотоод журмыг мөрдөн ажиллах зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Шилэн дансны тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Соёл, Спорт, Аялал Жуулчлал, Залуучуудын сайдын 2024 оны А/173 тоот тушаалын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 38,359.4 мянган төгрөгийн 4 залруулга, 45,624.2 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 687.2 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн. Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 38,359.4 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 43,819.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 687.2 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг тус тус хэрэгжүүлсэн, хэрэгжүүлээгүй 1,805.0 мянган төгрөгийн 1 алдаа, 2 зөвлөмжийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчилд оруулсан.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4,195.1 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоосноос хэрэгжилт 100 хувь, хариуцлага тооцох 1 албан шаардлага хүргүүлснээс хэрэгжилт 100 хувь, 48,698.8 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлснээс хэрэгжилт 100 хувь, 16,053.1 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснөөс хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 4* Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 4 | 4,195.1 | 4 | 4,195.1 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Хариуцлага тооцох албан шаардлага | 1 | 0.0 | 1 | 0.0 | 100% |
| Албан шаардлага | 3 | 48,698.8 | 3 | 48,698.8 | 100% |
| Зөвлөмж | 3 | 16,053.1 | 3 | 16,053.1 | 100% |
| **Нийт дүн** | **11** | **68,946.9** | **11** | **68,946.9** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа программ хангамж нь Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан " Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" - ын дагуу тайлан мэдээлэлийг илэрхийлж байгаа эсэхийг үзэх.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас үнэ төлбөргүй нийлүүлэгдсэн төгөлдөр хуур хөгжмийг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа эсэхийг үзэх.

Соёл, Спорт, Аялал Жуулчлал, Залуучуудын сайдын 2024 оны А/173 тоот тушаалаар баталсан байгууллагын дүрэмд удирдах зөвлөлтэй байхаар заасан бөгөөд Удирдах зөвлөлийг байгуулсан эсэхийг үзэх.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 42,811.9 мянган төгрөгийн 3 алдаа[1] илэрснээс аудитын явцад 42,811.9 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, алдааг  давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

*Залруулсан алдаа:*

- Санхүүгийн тайланд 7,206.3 мянган төгрөгийн өглөгийг тайлагнаагүй нь УСННБОУСтандартын заалт, нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй;
- Засварын ажлын гэрээний урьдчилгаанд төлсөн 21,793.6 мянган төгрөгийн төлбөрийг байгууллагаас авах авлагаар бүртгэж тайлагнасан байгаа нь УСННБОУСтандартын заалт, нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй;
- Харилцагч байгууллагад өглөг үүсгэн бараа материалын орлогоор бүртгэн тайлагнасан 13,812.0 мянган төгрөгийн 1900 ширхэг бараа материал нь бодитоор байхгүй байна.

Дээрх залруулсан алдаанууд нь УСННБОУСтандартын заалт, нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй;
Аудитаар нийт 33,136.0 мянган төгрөгийн 5 зөрчил илэрснээс 17,136.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлж, 16,000.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн 33,136.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

#### 5.1.1 Зардлын данстай холбоотой асуудал

Үнэлгээний хороонд ажилласан 1 хараат бус гишүүнд холбогдох журмын дагуу ажлын хөлсийг олгоогүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-т "Үнэлгээний хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр хурал байна" , Сангийн сайдын 2021 оны 103 дугаар тушаалын хавсралт 3,8-д " Захиалагч өөрийн ажилтан албан хаагч бус мэргэшсэн ажилтныг үнэлгээний хорооны гишүүнээр ажиллуулсан бол үнэлгээний хорооны хуралд оролцсон цаг тутамд дараахь хэмжээний урамшууллыг тооцон өөрийн төсөвт багтаан олгоно", 3.8.1-т " харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар, зөвлөх сонгох баг үнийг аргыг хэрэглэж болох төсөвт өртгийн дээд хязгаараас тус тус бага өртөгтэй тендер шалгаруулалтын хувьд цаг тутамд ТЗ-7 нэгдүгээр шатлалын нэг цагийн цалинтай тэнцэх " гэж заасантай тус тус нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Үнэлгээний хороонд ажилласан хараат бус гишүүнд холбогдох журмын дагуу ажлын хөлсийг олгож байх, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Сангийн сайдын 2021 оны 103 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах, албан шаардлага хүргүүллээ.

#### 5.1.2 Урьдчилж төлсөн тооцоо данстай холбоотой асуудал

Тайлант оны 9 сард 6,000.0 мянган төгрөгийн 900 ширхэг бараа материал бэлтгэхээр урьдчилан шилжүүлсэн төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

_Шийдвэрлэсэн нь:_ Урьдчилж шилжүүлсэн төлбөрийг харилцагч байгууллагатай тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх, албан шаардлага хүргүүллээ.

**5.1.3 Зардлын данстай холбоотой асуудал**

Захирлын 2025 оны 4 дүгээр сарын 25-ны Б/92 дугаар тушаалаар балансын урамшууллыг санхүү, аж ахуйн албаны ахлах нягтлан бодогч болон тооцооны нягтлан бодогч нарт 2 сарын, аж ахуйн нярав, кассын нярав, хувцасны эрхлэгч нарт 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний балансын урамшуулал нийт 9,936.0 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасантай нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

_Шийдвэрлэсэн нь:_ Хуульд заасан шалгуур хангаагүй байхад шагнал, урамшуулал олгодог зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

**5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**5.2.1. Төсвийн гүйцэтгэлийн тайлагналтай холбоотой асуудал**

_Илрүүлэлт:_Тайлант жилд 5,491,943.5 мянган төгрөгийн орлого болон зарлагын дүнтэй төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэсэн боловч нийт дүнгээр, хөтөлбөрөөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга зэргийг иж бүрэн тайлагнаагүй нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1-т "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна", 54.5.1-т "тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/", 54.5.2-т "татварын зарлагыг хуулийн этгээд, салбар бүрээр, холбогдох эрх зүйн үндэслэлийн хамт", 54.5.3-т "тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл", 54.5.4-т "хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/", 54.5.5-д "нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

_Өгсөн зөвлөмж:_ Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан бүрэлдэхүүний дагуу гаргаж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

**5.2.2. Бараа материалын зарцуулалт, хяналттай холбоотой асуудал**

_Илрүүлэлт:_Тайлант онд бараа материалын тайлангаар 16,000.0 мянган төгрөгийн шатахууныг зарцуулснаар тайлагнасан, зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсаар хяналт хийж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***<u>Өгсөн зөвлөмж</u>:*** Жолоочийн тооцооны хуудсыг хөтөлж, шатахуун зарцуулалтын тайланг гарган, тооцоо бодож баталгаажуулж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| № | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнэлэс Залруулсан | | Үнэлэс Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Санхүүгийн тайланд 7,206.3 мянган төгрөгийн өглөгийг тайлагнаагүй. | 1 | 7,206.3 | 1 | 7,206.3 | - | - | 1 | 7,206.3 | - | - | - | - |
| 2 | Харилцагч байгууллагад өглөг үүсгэн бараа материалын орлогоор бүртгэн тайлагнасан 13,812.0 мянган төгрөгийн 1900 ширхэг бараа материалыг хүлээж аваагүй байна. | 1 | 13,812.0 | - | - | 1 | 13,812.0 | 1 | 13,8120. | - | - | - | - |
| 3 | Засварын ажлын гэрээний урьдчилгаанд төлсөн 21,793.6 мянган төлбөрийг байгууллагаас авах авлагаар бүртгэж тайлагнасан байна. | 1 | 21,793.5 | - | - | 1 | 21,793.5 | 1 | 21,793.5 | - | - | - | - |
| | **Дүн** | **3** | **42,811.9** | **1** | **7,206.3** | **2** | **35,605.5** | **3** | **42,811.9** | **-** | **-** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо |
| 1 | Үнэлгээний хороонд ажилласан 1 гишүүний урамшууллыг ажилласан цагын бүртгэл, хуралд оролцсон баримт гэх мэт анхан шатны баримтад үндэслэн олгоогүй байна. | 1 | 1,200.0 | - | - | 1 | 1,200.0 | - | - | - | - |
| 2 | Тайлант оны 9 сард 6,000.0 мянган төгрөгийн 900 ширхэг бараа материал бэлтгэхээр урьдчилан шилжүүлсэн төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. | 1 | 6,000.0 | - | - | 1 | 6,000.0 | - | - | - | - |
| 3 | Захирлын 2025 оны 4 дүгээр сарын 25-ны Б/92 дугаар тушаалаар балансын урамшууллыг санхүү, аж ахуйн албаны ахлах нягтлан бодогч болон тооцооны нягтлан бодогч нарт 2 сарын, аж ахуйн нярав, кассын нярав, хувцасны эрхлэгч нарт 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний балансын урамшуулал нийт 9,936.0 мянган төгрөг олгосон байна. | 1 | 9,936.0 | - | - | 1 | 9,936.0 | - | - | - | - |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Тайлант онд бараа материалын тайлангаар 16,000.0 мянган төгрөгийн шатахууныг зарцуулснаар тайлагнасан, зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсаар хяналт хийж баталгаажуулаагүй. | 1 | 16,000.0 | - | - | - | - | 1 | 16,000.0 | - | - |
| 5 | Тайлант жилд 5,491,943.5 мянган төгрөгийн орлого болон зарлагын дүнтэй төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэсэн боловч нийт дүнгээр, хөтөлбөрөөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга зэргийг иж бүрэн тайлагнаагүй. | 1 | 0.0 | - | - | - | - | 1 | 0.0 | - | - |
| | **Дүн** | **5** | **33,136.0** | **-** | **-** | **3** | **17,136.0** | **2** | **16,000.0** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | |
| 1 | Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 5,940,000 төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй байна. | 1 | 5,940.0 | - | - | 1 | 5,940.0 |
| | **Дүн** | **1** | **5,940.0** | **-** | **-** | **1** | **5,940.0** |
| | Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | |
| 1 | Үндсэн үйл ажиллагааны нэмэлт эх үүсвэрээс худалдан авсан 18,325.0 мянган төгрөгийн үнэ бүхий 5 ширхэг компьютерыг цахим дэлгүүрээс худалдан аваагүй. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй. | 1 | 18,325.0 | 1 | 18,325.0 | - | - |
| 2 | Тайлант онд үндсэн үйл ажиллагааны нэмэлт эх үүсвэрээр стикер, карт болон паспортны гэр, тэмдэглэлийн дэвтрийн хавтас зэрэг 900 ширхэг 6,900.0 мянган төгрөгийн шаардлагагүй бараа материалын их хэмжээгээр бэлтгэхээр гэрээ байгуулан төлбөрийг шилжүүлсэн байна. | 1 | 6,900.0 | 1 | 6,900.0 | - | - |
| 3 | Байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2,955.6 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй тээврийн хэрэгслийг албан ёсны зогсоол, талбайд тавиагүй, бүрэн бүтэн байдалд өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлдэггүй, стандарт шаардлага хангасан агуулах байхгүйгээс 1 ширхэг 6,600.0 мянган төгрөгийн их хуур хөгжим эвдэрсэн, мөн бэлтгэл сургуулилт хийхээр гэрээр авч явсан хөгжмийн ашиглалтанд хяналтыг хэрэгжүүлээгүй. | 1 | 2,955.6 | - | - | 1 | 2,955.6 |
| 4 | Гэр медиа ХХК-тай байгуулсан "тасалбар худалдаалах зуучлалын гэрээ"-ны дагуу зуучлалын шимтгэлийг 2025 онд 3% гэж гэрээнд заасан боловч тайланд онд | 1 | 1,805.2 | - | - | 1 | 1,805.2 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тасалбар худалдаалсан шимтгэлд 4%-иар тооцож шимтгэл олгосон байна. | | | | | | |
| 5 | Үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах дүрэм, журмыг боловсруулан баталж мөрдөж ажиллаагүйгээс тайлант онд зохион байгуулсан 29 тоглолтын 611 ширхэг урилгыг бусдад харилцан адилгүй тоогоор олгосон. | 1 | 0 | - | - | 1 | 0 |
| 6 | Тайлант онд төвлөрүүлж, зарцуулсан үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого болох 526,459.2 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөө байхгүй. | 1 | 0 | - | - | 1 | 0 |
| 7 | Тайлант онд дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүй нийлүүлсэн 703,842.3 мянган төгрөгийн үнэ бүхий төгөлдөр хуур хөгжим нь ажлын даалгаврын шалгуур хангахгүй байгаа тул үйл ажиллагаанд ашиглагдахгүй байна. | 1 | 0 | - | - | 1 | 0 |
| 8 | Байгууллагын дүрэмд захиалгат тоглолтын үнийн тарифаас хөнгөлөлттэй үнээр үйлчилгээ үзүүлэх асуудлыг зохицуулаагүй байхад зарим төрийн байгууллага болон төрийн бус байгууллагуудад байгууллагын даргын тушаал шийдвэргүйгээр захиалгат тоглолтын үнийн тарифаас хөнгөлөлттэй үнээр үйлчилсэн байна. | 1 | 0 | - | - | 1 | 0 |
| | **Дүн** | **8** | **29,985.8** | **2** | **25,225.0** | **6** | **4,760.8** |
| | **Нийт дүн** | **9** | **35,925.8** | **2** | **25,225.0** | **7** | **10,700.8** |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 472/A0150122 Улаанбаатар хот

САГ-2026/237/НА-СТА-ТШ 3

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан дагуу Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Филармонийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны нэмэлт эх үүсвэрээр стикер, карт болон паспортын гэр, тэмдэглэлийн дэвтрийн хавтас зэрэг 900 ширхэг 6,900,000.00 (зургаан сая есөн зуун мянган) төгрөгийн шаардлагагүй бараа материалын их хэмжээгээр бэлтгэхээр гэрээ байгуулан төлбөрийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, шаардлагагүйгээр их хэмжээний бараа, материал бэлтгэн, нөөцөлдөг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Филармонийн захирал (С.Баттулга), ерөнхий нягтлан бодогч (Б.Сонинцэцэг) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | И.ЭРДЭНЭЦЭЦЭГ |
| ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ | Д.НАСАНЖАРГАЛ |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-60.Docx

1526181004

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 471/A0150/22 Улаанбаатар хот

СПП-2026/237/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан дагуу Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Филармонийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн үйл ажиллагааны нэмэлт эх үүсвэрээс худалдан авсан 18,325,000.00 (арван найман сая гурван зуун хорин таван мянга) төгрөгийн үнэ бүхий 5 ширхэг компьютерыг цахим дэлгүүрээс худалдан аваагүй. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, цахим дэлгүүрт байршсан барааг бусдаас худалдан авсан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй зэрэг зөрчлүүдийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Филармонийн захирал (С.Баттулга), ерөнхий нягтлан бодогч (Б.Сонинцэцэг) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Д.НАСАНЖАРГАЛ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 470/АО15012 Улаанбаатар хот
САГ-2026/237)НА-СТА-ТШ3

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан дагуу Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Филармонийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хэрхэн үр бүтээлтэй ажилласан болохыг тогтоохгүйгээр зөвхөн аудитаас өөрчлөлтгүй дүгнэлт авсан гэж Захирлын 2025 оны 4 дүгээр сарын 25-ны Б/92 дугаар тушаал гарган балансын урамшууллыг үндсэн чиг үүргийн ажлаа гүйцэтгэсэн санхүү, аж ахуйн албаны ахлах нягтлан бодогч болон тооцооны нягтлан бодогч нарт 2 сарын, аж ахуйн нярав, кассын нярав, хувцасны эрхлэгч нарт 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний балансын урамшуулалд нийт 9,936,000.00 (Есөн сая есөн зуун гучин зургаан мянга) төгрөг олгосон нь үндэслэх эрх зүйн шалгуур шаардлага хангахгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т “Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно.”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасантай тус тус нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хуульд заасан шалгуур хангаагүй байхад шагнал, урамшуулал олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Филармонийн захирал (С.Баттулга), ерөнхий нягтлан бодогч (Б.Сонинцэцэг) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Д.НАСАНЖАРГАЛ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*



1526181000

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр    Дугаар 469/А0150122    Улаанбаатар хот
САГ-2026/037/НА-СТА ПШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан дагуу Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Филармонийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны 9 сард 6,000,000.00 (Зургаан сая) төгрөгийн 900 ширхэг бараа материал бэлтгэхээр урьдчилан шилжүүлсэн төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;*" гэж заасантай тус тус нийцээгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-т "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дансны үлдэгдэл, төлбөр тооцоог тооцоо нийлсэн актаар баталгаажуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Филармонийн захирал (С.Баттулга), ерөнхий нягтлан бодогч (Б.Сонинцэцэг) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | И.ЭРДЭНЭЦЭЦЭГ |
| ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ | Д.НАСАНЖАРГАЛ |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-80.Docx

1526180998

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 468/АО150122 Улаанбаатар хот
САТ-2026/237/НА-СТА ТӨ-3

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан дагуу Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Филармонийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үнэлгээний хороонд ажилласан 1 гишүүний урамшуулал 1,200,000.00 (Нэг сая хоёр зуун мянга) төгрөгийг ажилласан цагийн бүртгэл, хуралд оролцсон баримт зэрэг анхан шатны баримтад үндэслэн олгоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д "Үнэлгээний хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр хурал байна", Сангийн сайдын 2021 оны 103 дугаар тушаалын хавсралт 3.8-д "Захиалагч өөрийн ажилтан албан хаагч бус мэргэшсэн ажилтныг үнэлгээний хорооны гишүүнээр ажиллуулсан бол үнэлгээний хорооны хуралд оролцсон цаг тутамд дараах хэмжээний урамшууллыг тооцон өөрийн төсөвт багтаан олгоно", 3.8.1-т "харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар, зөвлөх сонгох баг үнийг аргыг хэрэглэж болох төсөвт өртгийн дээд хязгаараас тус тус бага өртөгтэй тендер шалгаруулалтын хувьд цаг тутамд ТЗ-7 нэгдүгээр шатлалын нэг цагийн цалинтай тэнцэх", гэж заасантай тус тус нийцээгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т " хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үнэлгээний хорооны гишүүний ажилласан цагийн бүртгэл, хуралд оролцсон баримт зэрэг анхан шатны баримтад үндэслэн урамшуулал олгодоггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Филармонийн захирал (С.Баттулга), ерөнхий нягтлан бодогч (Б.Сонинцэцэг) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Д.НАСАНЖАРГАЛ